

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
МӨНГӨН ХӨРӨНГӨ, ҮНЭТ ЦААСНААС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ
АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ”

THE EXECUTION OF THE DECISION TO ENFORCING CASH,
SECURITIES



Э.Пүрэвжав

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны
сургуулийн 541 дүгээр дамжааны дэд түрүүч*

Товч утга: Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас төлбөр гаргуулах ажиллагааг эрх зүйн зохицуулалтын хүрээнд судалж, хэрэгжилтэнд тулгарч буй зарим асуудалд дүн шинжилгээ хийж, цаашид шийдвэрлэх арга замыг тодруулахад чиглэгдсэн.

Түлхүүр үг: Төлбөр төлөгч, төлбөр авагч, битүүмжлэх, худалдан борлуулах ажиллагаа, төлбөрт суутган шилжүүлэх

Abstract:Enforcing cash, securities in court decision enforcement will be studied in theory. The specifics of the legal regulation will be analyzed based on pratical results. The execution of the decision to enforcing cash, securities will be identifiied, and proposals will be developed.

Keywords: Payer, payment recipient, sales activity, payment transfers

Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгчийн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг зохион байгуулахдаа хуульд заасан дараалал, арга, журмын дагуу албадан гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулдаг. Ийнхүү шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч этгээд өөрийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг бусдын нэр дээр бүртгүүлэх, шилжүүлэх, бэлэглэх зэргээр

хөрөнгөө нуун дарагдуулж мөн үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулж үнэт цаас, хувьцаа худалдан авч түүнээсээ ашиг олох байдал нь эрх зүйн зохицуулалт, энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны туршлага бага байгаагаас хөрөнгөө нуун дарагдуулах нөхцөл байдлыг бий болгоход нөлөөлж болзошгүй байна.

Тиймээс төлбөр авагчдын зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэхэд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг илүү боловсронгуй болгож шинэ шатанд хэрэгжүүлэх, шинэ арга хэлбэрээр явуулах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгараад байна.

Мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал: Шийдвэр гүйцэтгэгч нь тухайн орчин нөхцөлд тохирсон ажиллагааг хэрэгжүүлэх ба төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээд болон тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал нь өөр өөр байдаг. Үүнээс төлбөр төлөгч иргэний хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа дараах дарааллын дагуу гүйцэтгэнэ.

Үүнд:

1. Бэлэн болон бэлэн бус мөнгөн хөрөнгө;
2. Үнэт цаас;
3. Хөдлөх хөрөнгө;
4. Үл хөдлөх хөрөнгө;
5. Эдийн бус хөрөнгө гэх дараалалаар гүйцэтгэх ба эдгээр хөрөнгийг дэлгэрүүлэн авч үзвэл:

1. Бэлэн болон бэлэн бус мөнгөн хөрөнгө

Бэлэн мөнгө гэдэг нь нийгмийн болон хууль ёсны хувьд хүлээн зөвшөөрөгдсөн, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, өр ширийг төлөх зориулалттай зүйл ба бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрт төлж болох санхүүгийн хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, мөнгө нь ямар ч таваараар солигдож чадах хөрвөх чадвар сайтай арилжаа, гүйлгээний хэрэгсэл юм.¹

Бэлэн бус мөнгөн хөрөнгө гэдэг нь шууд утгаараа гүйлгээний хэрэгсэл болдоггүй боловч ямар нэгэн алдагдал эрсдэлгүйгээр бэлэн мөнгө болгох боломжтой цахим мөнгө байдаг ба бэлэн бус мөнгийг төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий төлбөрийн хэрэгсэл хэмээн тодорхойлсон байдаг.² Мөн төлбөр төлөгчийн бэлэн бус мөнгө гэдэгт банк эрх бүхий хуулийн этгээд дэх

¹Мөнгөн хөрөнгийн удирдлага <https://docs.google.com/> Татаж үзсэн. 04.02.2023

²Үндэсний төлбөрийн системийн тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №28.

хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, валют¹ зэргийг хамааруулан ойлгож болно.

"Үндэсний валют"² гэж эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөг, түүгээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ.

"Гадаад валют"³ гэж эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий нэг буюу хэд хэдэн гадаад улсын мөнгөн тэмдэгт, тэдгээрээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ. Гадаад валютыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрснөөр чөлөөтэй хөрвөдөг ба чөлөөтэй хөрвөдөггүй гэж ангилна.

2. Үнэт цаас;

Иргэний гүйлгээнд эд юмс, мөнгөн тэмдэгт, эд хөрөнгийн эрхээс гадна албан ёсны баримт бичиг болох үнэт цаас чухал үүрэг гүйцэтгэдэг. Үнэт цаасыг эзэмшигч нь түүнээс үүсэх эрхийг мөн адил хэрэгжүүлэгч байдаг.⁴

"Үнэт цаас" гэж хувьцаат компанийн хувьцаа, компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх, хадгаламжийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, санхүүгийн хорооноос үнэт цаас гэж тогтоосон бусад санхүүгийн хэрэгсэл⁵ хэлнэ.

Санхүүгийн хэрэгсэл гэж үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, мөнгөний болон зохицуулалттай зах зээлд арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслийг хэлнэ.⁶

Үүсмэл санхүүгийн хэрэгсэл /дериватив/" гэж опцион гэрээ болон фьючерсийн гэрээ, зохицуулалттай зах зээлд арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслийг хэлнэ.

¹ Валютын зохицуулалтын тухай хууль. УБ., 1994. Төрийн мэдээлэл эмхэтгэл №6. "Валют" гэж Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг.

² Валютын зохицуулалтын тухай хууль. УБ., 1994. Төрийн мэдээлэл эмхэтгэл №6.

³ Валютын зохицуулалтын тухай хууль. УБ., 1994. Төрийн мэдээлэл эмхэтгэл №6.

⁴ Жамбалдорж, О. Монгол улсын иргэний эрх зүй. 2004. 177 дахь тал.

⁵ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль. УБ., 2013. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

⁶ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль. УБ., 2013. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

Опцион гэрээ гэж гэрээний зүйл болох тодорхой тоо, хэмжээ бүхий хөрөнгийг тохиролцсон үнээр тогтоосон хугацаанд худалдан авах, эсхүл худалдахыг нөгөө талаас шаардах эрхийг нэг талд үүсгэх боловч үүргийг бий болгодоггүй, харин нөгөө талд уг шаардлагыг биелүүлэх үүргийг үүсгэдэг үүсмэл санхүүгийн хэрэгсэл юм.

Фьючерсийн гэрээ гэж талууд тодорхой тоо, хэмжээ бүхий хөрөнгийг урьдчилан тохиролцсон үнээр тогтоосон хугацаанд худалдах, худалдан авах үүргийг гэрээний талуудад үүсгэх гэрээ буюу үүсмэл санхүүгийн хэрэгсэл юм.

Үнэт цаас нь биет болон биет бус гэсэн төрөлтэй. Тогтоосон журмын дагуу хэвлэсэн үнэт цаасыг биет, тусгайлан хэвлээгүй бүрдүүлбэр нь тусгай бүртгэлд байгаа үнэт цаасыг биет бус үнэт цаас гэнэ.

3. Хөдлөх хөрөнгө;

Эд хөрөнгийг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө гэж ангилдаг. Хөдлөх хөрөнгө нь “Иргэний хууль”¹-д зааснаар үл хөдлөх хөрөнгөөс бусад төрлийн эд хөрөнгө юм. Үл хөдлөх хөрөнгийн бүрдэл хэсэг байсан зүйл нь газраас болон тухайн үл хөдлөх хөрөнгөөс салгагдсанаар хөдлөх хөрөнгийн ангилалд багтах боломжтой байдаг.²

Хөдлөх эд хөрөнгийн нэр төрлийг жагсаах, нэрлэн заах боломжгүй юм. Гэхдээ хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй хөдлөх эд хөрөнгийн төрлийг дараах байдлаар жагсаан нэрлэж болох юм.³ Үүнд:

- тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмж;
- бараа материал, түүхий эд;
- мөнгөн урсгал;
- биет бус хөрөнгө;
- үр тариа, мал сүрэг;
- үл хөдлөх хөрөнгөтэй холбогдсон хөдлөх хөрөнгүүд;
- хэрэглээний бараа;
- бэлэн мөнгө, хадгаламжийн данс;
- шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл;
- шинэ бүтээл бүтээгдэхүүний загвар;
- барааны тэмдэг;

¹Иргэний хууль. Уб., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7.

²Баярмаа, Н. Эрдэнэчимэг, Д. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцаа гарын авлага. Уб., 2017. 5 дахь тал.

³Баярмаа, Н. Эрдэнэчимэг, Д. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцаа гарын авлага. Уб., 2017. 5 дахь тал.

- ашигтай загвар.

Хөдлөх хөрөнгийг ийнхүү ангилан хувааснаар, тухайн эд хөрөнгийн үндсэн шинж, зориулалт, эрх зүйн болон эдийн засгийн ач холбогдлыг мэдэж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай явуулахад боломжтой болох юм.

4. Үл хөдлөх хөрөнгө;

Үл хөдлөх хөрөнгө нь хүний амьдралын гол хэрэгцээ болох оршин суух, аж төрөх боломжийг бий болгодгоороо давуу талтай. Үл хөдлөх хөрөнгийг ашигт байдал, хүний хэрэгцээг хангах чадвараар нь үнэ цэнийг тодорхойлж байдаг.

Үл хөдлөх хөрөнгө гэж газар, түүний дээр ургаж байгаа ургамал, тарьц болон газартай салшгүй бэхлэгдсэн барилга, байгууламж болон хуульд тусгайлан заасан бусад эд юмс хамаарна. Бидний хамгийн үл хөдлөх хөрөнгөд газар, түүний баригдаж, салгах боломжгүйгээр холбогдсон барилга, салгах боломжгүйгээр холбогдсон барилга, байгууламж хамаарна.

Үл хөдлөх хөрөнгийг тодорхойлох эдийн засгийн шинж

Үл хөдлөх хөрөнгө нь эдийн засгийн баялгийг ашиглах, бүтээхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг. Үл хөдлөх хөрөнгө нь үндэсний баялгийн тулгуур ойлголт ба түүний зах зээлийн хөгжил нь эдийн засгийн өсөлтийн хамгийн чухал хүчин зүйлсийн нэг юм.

Үл хөдлөх хөрөнгийг тодорхойлох эрх зүйн шинж

Үл хөдлөх хөрөнгө нь өмчлөх, өвлөх, бэлэглэх, худалдах, барьцаалах, даатгах зэрэг олон тооны иргэний эрх зүйн харилцаанд байнга оролцдог. Эрх зүйн үүднээс зарим хөрөнгийг шууд үл хөдлөх хөрөнгө гэдэгт хамруулж байгаа нь тухайн хөрөнгийг бүртгэлтэй болгох, хяналт тавьж зохицуулах арга гэж үзэж байна.

5. Эдийн бус хөрөнгө

Эдийн бус харилцаа гэдэг нь үйлдвэрлэл, мэдээлэл, урлаг, утга зохиолын салбарт явуулж буй баялгийг ашиглахтай холбоотойгоор үүсдэг харилцааг хэлнэ.¹

Үүнд:

- Оюуны үнэт зүйл
- Шаардах эрх
- Зохиогчийн эрх
- Аж үйлдвэрлэлийн өмч

Өөрөөр хэлбэл эдийн бус хөрөнгө нь та бидний гарт баригдаж нүдэнд үзэгдэхгүй боловч тодорхой үнэ цэнийг өөртөө агуулж байдаг биет бус баялаг юм.

¹Оюунтунгалаг,Ж. Иргэний эрх зүй ерөнхий анги. Уб., 2020. 33 дахь тал.

Иргэний хуулийн 83 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болон оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг хөрөнгө болно¹” гэж заасан байдаг.

Эдийн болон эдийн бус хөрөнгийн эрх зүй дэх өмчийн хэлцэл нь хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэсэн төрөлтэй байдаг. Эдийн болон эдийн бус харилцаатай холбоотой хөрөнгийн тусгайлсан эрхүүд байдаг ба өмчлөх бүрэн эрх, хөрөнгийн хязгаарлагдмал эрх гэж байдаг.

Дээрх дарааллын дагуу баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаас, цалин хөлс, бусад орлогоос, хөдлөх эд хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө (гуравдагч этгээдэд холбогдох бараа, ажил үйлчилгээ нийлүүлсний төлбөрийг шаардах эрх, гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгчийн шаардах эрх, оюуны өмчийг эзэмших, ашиглах, өмчлөх болон тэдгээртэй холбоотой шаардах эрх, төлбөр төлөгчийн эдийн бус бусад хөрөнгө)-өөс, дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх төлбөрийн шаардлага хангахуйц хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг зохион байгуулдаг.

Эдгээр ажиллагаанаас хамгийн түгээмэл хийгддэг ажиллагаа болох төлбөр төлөгчийн банк дахь мөнгөн хөрөнгөөс суутгал хийх ажиллагааны талаар дэлгэрүүлэн авч судалж үзлээ.

Шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээдэд байх дансны мэдээллийг шийдвэр гүйцэтгэгчээс хөрөнгийн мэдүүлэг авахад тодруулах ба төлбөр төлөгч эзэмшиж, ашиглаж байгаа дансны мэдээллээ өгөөгүй эсвэл хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол Банкны тухай хуулийн 7.2.7 дахь заалтыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн даргын зөвшөөрлөөр банк, эрх бүхий этгээдээс дансны мэдээлэл, орлого, зарлагын гүйлгээг тодруулна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасны дагуу төлбөр төлөгчийн бие болон эд зүйлд үзлэг хийх ба бэлэн мөнгө илэрсэн тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагын хэмжээнээс илүүгүй хэмжээгээр хураан авах ба хэрэв бэлэн мөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагын хангахгүй байгаа тохиолдолд бэлэн бус мөнгө буюу

¹Иргэний хууль. УБ., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7.

тухайн төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх харилцах болон хадгаламжийн дансанд байгаа хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэдэг.

Шийдвэр гүйцэтгэгч нь бусад этгээдийн дансны мэдээлэл, данс дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх шийдвэр гаргахын өмнө төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдээс бусдын нэр дээр бүртгэлтэй мөнгөн хөрөнгийг захиран зарцуулж байгааг шалган тогтоосон байх шаардлагатай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 50 дугаар зүйлийг удирдлага болгон төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх төлбөр төлөгчийн дансны дугаар, төрөл, данс эзэмшигчийн нэр лавлагаа тодорхойлолтыг гаргуулан авах, данс дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх, гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагын хэмжээгээр төлбөрт суутгах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулдаг ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/167 дугаар тушаалаар батлагдсан 36 дугаар маягтын дагуу Банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах данс дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих тухай шийдвэрийг хүргүүлж, дансыг битүүмжилдэг.

Мөнгөн хөрөнгө битүүмжлэхдээ төлбөр төлөгчийн дараах эрхэд хязгаарлалт тогтоон банк, эрх бүхий хуулийн этгээдэд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгана.

- битүүмжлэгдсэн мөнгөн хөрөнгийг төлбөрийн үнийн дүнгийн хэмжээгээр хасалт хийж, төлбөрийн дансанд шилжүүлэх;
- төлбөр төлөгчид шинээр данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох;
- дансны орлого, зарлагын гүйлгээ болон битүүмжлэгдсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн талаар мэдээлэл ирүүлэх.

Төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө битүүмжлэх, суутгал хийх шийдвэрийг шийдвэр гүйцэтгэх албанаас харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэрээ байгуулсан бүх арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллага, гэрээ хэлцлийн үндсэн дээр төлбөр төлөгчид үүрэг хүлээсэн гуравдагч этгээд цахим хэлбэрээр шийдвэр хүргүүлэх ба гэрээ байгуулаагүй бол бичгээр шийдвэрийг хүргүүлдэг.

Шийдвэр гүйцэтгэгч нь хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд төлбөр төлөгчийн эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмын дагуу

мэдээлэл цуглуулах, төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, худалдан борлуулах гэх мэт ажиллагааг явуулдаг бөгөөд төлбөр төлөгчийн цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийх ажиллагааг мөн адил хэрэгжүүлдэг.

Цалин хөлс, бусад орлогоос төлбөр гаргуулахдаа төлбөрт гаргуулж болохгүй орлогыг хасах¹ ба төлбөр төлөгчийн нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хассан цалин хөлсний дүнгийн 20 хувиас, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, эсхүл хэд хэдэн суутгал зэрэг хийх бол цалин хөлсний 50 хувиас хэтрэхгүй байна.²

Төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах данс дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих гэсэн зүйл заалт нь хэтэрхий ерөнхий утгаар авч үзсэн байна.

Эрх бүхий хуулийн этгээд гэдэгт нь ямар байгууллагуудыг оруулах, ямар байгууллагаас лавлагаа мэдээлэл авах зэрэг нь тодорхой биш байгаа учраас төлбөр төлөгчийн хөрөнгийн мэдээллийг дутуу авах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах нөхцөл үүсч байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 513 байгууллага байна. /хавсралт 3/ Үүнээс мөн адил 2022 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 30.1 хувиар буюу 817.0 тэрбум төгрөгөөр өсөж 3.5 их наяд төгрөгт хүрсэн байна.

¹Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээллийн эмхэтгэл №24. 88 дугаар зүйлийн 88.1.Төлбөр төлөгч-иргэний дараахь орлогоос төлбөр гаргуулж болохгүй: гамшиг аюулт үзэгдэл, онцгой нөхцөл байдлын улмаас үзүүлж байгаа тусламж, тэтгэлэг хандив, илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс, нэг удаагийн урамшуулал, ажлаас халагдсаны тэтгэмж, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу олгож байгаа хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, донорт олгож байгаа нөхөх олговрын мөнгө, нэмэгдэл хоол, амралт, сувиллын эмчилгээ, хиймэл эрхтэн хийлгэхэд зориулан олгосон зардал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний, тэжээн тэтгэгчээ алдсаны тэтгэмж, тэтгэвэр, хүүхдийн болон сургалтын байгууллагын тэтгэлгийн мөнгө, эрүүл мэндэд учруулсан хохирлын нөхөн төлбөр, хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу олгож байгаа тэтгэмж, тэтгэлэг.

²Хөдөлмөрийн тухай хууль. Уб., 2021. Төрийн мэдээлэл эмхэтгэл №31.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 66.5 хувиар буюу 346.6 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 78.3 хувиар буюу 243.7 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 49.0 хувиар буюу 102.9 тэрбум төгрөгөөр өссөн гэсэн тоон судалгаа гарсан байгаа нь төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгөө банк бус санхүүгийн байгууллагад шилжүүлэх, нуун дарагдуулах үндэслэл бий болж байна гэж дүгнэж байна. Тиймээс эдгээр банк бус санхүүгийн байгууллагаас лавлагаа мэдээлэл гаргуулах шаардлагатай юм.

Үнэт цааснаас төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал: Одоогоор Монгол Улсын их хурлаас 2002 оны 2 дугаар сарын 12-ны өдөр баталсан “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийг даган мөрдөж байна. Энэ хуулийн зорилт нь үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргах, бүртгэх, хадгалах, худалдах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэт цаасны талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршдог.¹

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “үнэт цаасны зах зээл” гэж үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгүүлэх, гаргах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх, төлбөр, тооцоо гүйцэтгэх, хадгалах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зохицуулалттай зах зээлийн болон биржийн бус зах зээлийн харилцааг хэлнэ”² гэж тусгажээ.

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн үнэт цааснаас төлбөр гаргуулах ажиллагааг гүйцэтгэхдээ үнэт цаасны зах зээлийн тухай хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг удирдлага болгон ашигладаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу үнэт цааснаас төлбөр барагдуулах ажиллагааны хүрээнд хэд хэдэн онцлог, тусгайлсан ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ. Үүнд:

1. Үнэт цаас байгаа эсэх талаар мэдээлэл цуглуулах
2. Үнэт цаас, мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх
3. Үнэт цаас битүүмжлэх, хураах
4. Үнэт цаас худалдан борлуулах

Үнэт цааснаас төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шат:

¹Үнэт цаасны зах зээлийн тухай хууль. Уб., 2013. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

² Үнэт цаасны зах зээлийн тухай хууль. Уб., 2013. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

Шийдвэр гүйцэтгэгч нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд төлбөр төлөгчийн эзэмшилд үнэт цаас, хувьцаа, үнэт цаасны данс байгаа эсэхийг тодруулахаар албан тоот хүргүүлэх ба үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь тухайн төлбөр төлөгчийн нэр дээр үнэт цаас эзэмшдэг данс байгаа эсэх талаарх лавлагаа мэдээллийг хүргүүлдэг.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас явуулж байгаа албан бичиг нь зөвхөн үнэт цаас эзэмшдэг эсэх талаар мэдээллийг гаргуулан авч түүний эзэмшдэг дансыг битүүмжлэх шийдвэрийг хүргүүлдэг. Гэвч тухайн төлбөр төлөгч өөрийн хөрөнгө буюу үнэт цаасыг бусдын нэр дээр шилжүүлэх, бэлэглэх зэргээр нуун дарагдуулдаг байна.

Үнэт цаасыг шилжүүлснээр өмчлөх эрх шилжсэнд тооцох ба үнэт цаасыг өөр этгээдэд шилжүүлснээр гэрчлэгдэж байгаа эрх бүхэлдээ шилжинэ. Үнэт цаасыг өмчлөгч буюу түүнээс уг эрхийг шилжүүлж авахаар өөрийн нэр дээр холбогдох бичилт хийлгэсэн этгээд үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдэлнэ.

Хэрэв төлбөр төлөгч нь үнэт цаастай нь тогтоогдсон бол шийдвэр гүйцэтгэгч нь биет үнэт цаасыг эзэмшилдээ авах ба биет бус үнэт цаасыг битүүмжлэх тухай шийдвэрийг эрх бүхий хуулийн этгээдэд буюу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хүргүүлнэ.

Үнэт цаасыг битүүмжлэх шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн шийдвэр гүйцэтгэгч тогтоолт үйлдэх ба төлбөр төлөгчийн эзэмшлийн үнэт цаасны захиран зарцуулах эрх эсвэл гуравдагч этгээдийн үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа гаргах эрхийг тус тус түдгэлзүүлнэ. Шаардлагатай бол үнэт цаастай холбоотой бусад эрхийг хязгаарладаг.

1. Үнэт цаасыг битүүмжилсэн тохиолдолд ногдол ашиг хүртэх эрхийг хязгаарлаж, ногдол ашиг хуваарилах эрх бүхий этгээдэд хуваарилсан ногдол ашгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлэх тухай мэдэгдэл хүргүүлнэ.
2. Үнэт цаасыг арилжих, бүртгэх, төлбөр тооцоо гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд буюу төвлөрсөн хадгаламжийн төв нь төлбөр төлөгчийн үнэт цаасыг битүүмжлэх шийдвэрийг хүлээн авмагц хязгаарлагдсан эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа гүйлгээг даруй зогсоож, ногдол ашиг хүртэх эрхийг түдгэлзүүлнэ.

Одоогоор санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 277 зохицуулалттай этгээд байна. Эдгээрийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ	ТОО
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	3
2	Үнэт цаасны тооцооны байгууллага	21
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Үнэт цаасны төлбөрийн байгууллага	1
5	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	38
6	Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/	4
7	Кастодиан банк	3
8	Үнэт цаасны компани	52
9	Брокер	51
10	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч	13
11	Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч	14
12	Хөрөнгө итгэмжлэн удирдах	8
13	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	1
14	Тусгай зөвшөөрөлтэй компани /ХБҮЦ гаргагч/	493
15	Хөдөө аж ахуйн бирж	1
16	Хөдөө аж ахуйн брокер	10
17	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага	1

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь үнэт цаасыг арилжих, бүртгэх, төлбөр тооцоо гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд төлбөр төлөгчийн тухайн үнэт цаасны захиран зарцуулах эрхийг царцаах буюу битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэх үүргийг даалгадаг. Үүний дараа брокерын компаниар дамжуулан үнэт цаас худалдах ажиллагааг явуулах ба үнэт цаасны үнэ, төлбөрийн хэрэгсэл болох аливаа шинж чанарыг дордуулахгүйгээр шаардлагатай арилжааг хийж, арилжааны үр дүнд бий болсон үнэт цаас, бусад хөрөнгө нь битүүмжлэгдсэнд тооцогдох бөгөөд арилжааг гүйцэтгэсэн этгээд арилжаа хийсэн тухай шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 63.7 дугаар зүйлд “Үнэт цаасны албадан дуудлага худалдааг тухайн үнэт цаасны төлбөр, тооцоо, бүртгэл, хариуцсан байгууллага хариуцан гүйцэтгэнэ”¹ гэж тусгаж өгсөн байдаг.

Иймд шийдвэр гүйцэтгэгч нь худалдан борлуулах тухайн хөрөнгийг зах зээлд арилжаа зохион байгуулж байгаа эрх бүхий этгээд буюу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд тухайн хөрөнгийг худалдан борлуулах үүргийг хүлээлгэдэг.

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад Монголын хөрөнгийн бирж ХК, Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж дараах байдлаар худалдан борлуулдаг.

1. Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс төлбөр төлөгчийн үнэт цаас эзэмшиж байгаа эсэх талаар дэлгэрэнгүй судалгааг гаргуулан авах;
2. Үнэт цаас худалдан борлуулах эрхтэй брокер дилерийн компанийг сонгох, гэрээ байгуулах;
3. Сонгосон брокер дилерийн компанитай хамтран ажилладаг арилжааны банканд үнэт цаас худалдан борлуулсан орлогыг төвлөрүүлэх данс² нээлгэх;
4. Монголын хөрөнгийн бирж ХК-аас төлбөр төлөгчийн эзэмшлийн үнэт цаасны хаалтын ханш, сүүлийн 6 сарын дундаж ханш зэрэг мэдээллийг авах;
5. Брокер дилерийн компанид үнэт цаасыг дуудлага арилжаагаар худалдан борлуулах захиалга өгөх;
6. Нээлгэсэн дансанд төлбөр төлөгчийн үнэт цаасыг худалдан борлуулсан орлогыг төвлөрүүлж, захиран зарцуулах эрхийг тус албаны эрх бүхий албан хаагч /шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, дэд дарга, дарга/-д олгохыг мэдэгдэх;

Үнэт цаасыг худалдан борлуулахдаа хөрөнгө үнэлэх ажиллагааг гүйцэтгэхгүйгээр шууд худалдан борлуулж байгаа бөгөөд аливаа үнэт цаас нь өөрөө зах зээлд тодорхой үнэлгээтэй, тогтсон арилжааны ханштай байдгаас шалтгаалж байна. Үүнээс үзэхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад үнэт цааснаас төлбөр гаргуулах ажиллагаа нь дараах онцлогтой байна. Үүнд:

1. Хураан авах битүүмжлэх ажиллагааг нэгэн зэрэг хамт хийх

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээллийн эмхэтгэл №24.

² “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам” 2 дугаар зүйлийн 2.1.3. “данс” гэж Үнэт цаасны компаниар дамжуулан ҮЦТХТөвд нээлгэсэн үнэт цаасны данс, биржийн бус мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон төлбөр тооцоо хийх үүрэг бүхий данс

2. Худалдан борлуулах ажиллагааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх
3. Хөрөнгө үнэлүүлэх ажиллагаа зохион байгуулахгүйгээр худалдан борлуулах, суутгах
4. Албадан дуудлага худалдааг явуулахыг энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий этгээдэд үүрэг болгох.

Шийдвэр гүйцэтгэгч нь үнэт цаасыг худалдан борлуулж байгаа эрх бүхий брокерын компанид тухайн үнэт цаасыг худалдан борлуулсан тохиолдолд орлогыг дансанд шилжүүлэх мэдэгдлийг өгнө. Үнэт цаасны арилжаа гүйцэтгэхийг брокерын компанид даалгахдаа үнэт цаас худалдан борлуулах¹ хугацаанд нийцүүлэн борлуулах, арилжаа хийх үндэслэлийг мэдэгдэнэ. Энэ хугацаа нь төлбөр төлөгчийн бусад хөрөнгийг албадан дуудлага худалдаагаар борлуулах хугацаа юм.

Худалдан борлуулагдаагүй үнэт цаасыг дуудлага худалдаанд тавьсан өдрийн сүүлийн цагийн ханшаар төлбөр авагчид санал болгоно.² Харин талууд хүсэлт гаргасан, эвлэрсэн тохиолдолд үнэт цаасыг худалдаанд тавьсан сүүлийн цагийн үнээр³ бус дээрх дундаж ханшаар тооцож шийдвэрлэж болно.

Үнэт цааснаас төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг одоогийн мөрдөгдөж байгаа хууль болон өмнөх үеийн хууль, эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалгаа хийлээ.

Битүүмжлэх ажиллагааны хувьд:

Хүснэгт №2

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль 1996 он	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
-Төлбөр	Төлбөр	-Үнэт цаас, вексель
төлөгчийн төлбөрт гаргуулах хөрөнгийг ангилан авч тусгаагүй, битүүмжлэх	төлөгчийн төлбөрт гаргуулж болох үнэт цаас, эдийн бус хөрөнгийг бусад хөрөнгөөс ялгаж	зэргийг битүүмжлэх ажиллагааг нарийвчлан өгсөн.
		-Битүүмжлэх, барьцаалах ажиллагаанд

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээллийн эмхэтгэл №24. 63 дугаар зүйлийн 63.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 64.5-д зааснаас бусад хөрөнгийг түүний үнэлгээг тогтоосноос хойш 2 сарын дотор, төлбөр төлөгчийн өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах тухай саналыг хүлээн авсан тохиолдолд 3 сарын дотор албадан худалдан борлуулах ажиллагааг явуулна.

² Өнөрцэцэг, Ч. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал эрх зүйн зохицуулалт. Уб., 2022. 99 дэх тал.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээллийн эмхэтгэл №24.

барьцаалах ажиллагаанд төлбөр төлөгчийн хөрөнгийн онцлогийг тусгаагүй ерөнхийд нь шийдсэн.	өгсөн.	хураан авах ажиллагааг шууд гүйцэтгэх тохиолдлыг тусгаж өгсөн. -Үнэт цаас түүний ашиг, орлогоос төлбөр гаргуулах боломжтой болсон.
---	--------	---

Хураах, худалдан борлуулах ажиллагааны хувьд:

Хүснэгт №3

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль 1996 он	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
-Төлбөр төлөгчийн шаардах эрх, үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхүүдийг хэрхэн төлбөрт гаргуулах талаар зохицуулалт байхгүй.	-Үнэт цаас, хувьцаа болон бусад хөрөнгийн худалдааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр тусгаж өгсөн.	-Зайлшгүй үнэлгээ хийлгэх хөрөнгийг тусгаж өгсөн -Үнэлгээ хийлгэхгүйгээр худалдан борлуулах үндэс тавигдсан -Үнэт цаасыг худалдан борлуулах ажиллагааг ерөнхийд нь тусгасан.

Судалгаанаас харахад Улсын их хурлаас 2017 он шинэчлэн найруулж баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд үнэт цаас худалдан борлуулах талаар тодорхой тусгаж өгсөн нь өмнөх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд байгаагүй шинэлэг зохицуулалт болжээ.

Хэдийгээр үнэт цаасыг худалдан борлуулахдаа үнэлгээ тогтоохгүй байхаар хуулиар зохицуулсан боловч энэ нь тухайн үнэт цаасны зах зээлд зарагдаж байгаа үнээр худалдах үнийг тодорхойлсон агуулга юм.

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд шүүх болон бусад байгууллагаас гаргасан шийдвэр, эрх зүйн баримт бичгийн үндсэн дээр бусдын хуулиар хамгаалагдсан зөрчигдсөн эрхийг сэргээж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахтай холбоотой нийгмийн тодорхой харилцаа зохицуулж байдаг.

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн бүхий л хөрөнгийг олж тогтоож төлбөр гаргуулах ажиллагааг гүйцэтгэдэг ба эдгээрээс мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас төлбөр гаргуулах ажиллагааг дэлгэрүүлэн судаллаа.

Төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах данс дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих гэсэн зүйл заалт нь хэтэрхий ерөнхий утгаар авч үзсэн гэж дүгнэж байна. Эрх бүхий хуулийн этгээд гэдэгт нь ямар байгууллагуудыг оруулах, ямар байгууллагаас лавлагаа мэдээлэл авах зэрэг нь тодорхой биш учраас төлбөр төлөгчийн хөрөнгийн мэдээллийг дутуу авах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах нөхцөл үүсэж байна.

Мөн төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгөөс гадна үнэт цааснаас төлбөр гаргуулах ажиллагааг хэрэгжүүлэхгүй байгаа нь судалгаанаас харахад үнэт цааснаас төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалт дутмаг, үнэт цаасыг төлбөрт тооцон шилжүүлэхэд хүндрэлтэй байдаг гэж шийдвэр гүйцэтгэгч нар санал өгсөн байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь үнэт цааснаас төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв рүү албан тоот явуулах, данс эзэмшиж байгаа тохиолдолд захиран зарцуулах эрхийг нь түдгэлзүүлэхээс өөр арга хэмжээ авдаггүй ба хувьцааг худалдан борлуулах ажиллагааг тэр бүр хийдэггүй, битүүмжилсэн хувьцаанаас төлбөр гаргуулж чадахгүй байгаа нь дадлагын хугацаанд харагдаж байсан. Энэ нь шийдвэр гүйцэтгэгч нарын үнэт цааснаас төлбөр гаргуулах талаарх мэдлэг ур чадвар дутмаг, энэ төрлийн ажиллагааг явуулж байсан туршлага байхгүйгээс хувьцааг худалдан борлуулах талаар идэвхи чармайлт гаргадаггүй гэж судлаач миний хувьд дүгнэж байна.

Мөн төлбөр төлөгчийн үнэт цаасны талаарх мэдээллийг цуглуулах үе шат буюу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв рүү явуулж байгаа албан бичигтээ шилжүүлсэн, бэлэглэсэн талаар мэдээллийг давхар тодруулах шаардлагатай юм.

Тиймээс шийдвэр гүйцэтгэгч нарт үнэт цаас худалдан борлуулах талаар гарын авлагатай болгох, шийдвэр гүйцэтгэгч нар үнэт цаас, хувьцааны талаар мэргэжлийн байгууллагаас сургалт орох, мэдээлэлтэй болгох шаардлагатай юм.

САНАЛ

Төлбөр төлөгч иргэн болон хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлд байх мөнгөн хөрөнгө буюу бэлэн мөнгө, банк, банк бус санхүүгийн байгууллага дах хадгаламжийн болон харилцах дансны хөрөнгө, цалин хөлс бусад орлогоос суутгал хийх, мөн үнэт цааснаас төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар судлан үзэж энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор дараах саналыг гаргаж байна.

Үүнд:

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

1. Үнэт цаас нь үнийн хэлбэлзэл ихтэй байдаг учраас үнэт цаасны дансыг битүүмжилсэн даруйд худалдан борлуулах захиалга өгөх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгах;

2. Банк, эрх бүхий хуулийн этгээд гэсэн нэр томьёог Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд илүү тодорхой болгож эрх бүхий хуулийн этгээд гэдэгт ямар байгууллагууд байхыг тусгаж өгөх;

3. Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос арилжааны банкнуудтай нэгэн адил цахимаар болон албан бичгээр төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгийн талаар мэдээлэл авах, суутгал хийх эрх зүйн орчин бүрдүүлэх;

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

1. Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодоос төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгийн талаар мэдээлэл авах, суутгал хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх;

2. Шийдвэр гүйцэтгэх албаны бүтцэд төлбөр төлөгчийн эзэмшлийн үнэт цаасыг худалдан борлуулах ажиллагааг хариуцсан мэргэжилтний орон тоог бий болгох, энэ төрлийн ажиллагаанд хяналт тавьж мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах;

3. Үнэт цаас болон түүнээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар шийдвэр гүйцэтгэгч нар өдөр тутамдаа хэрэглэх гарын авлагатай болох.

Үйл ажиллагааны чиглэлээр:

1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв рүү явуулж байгаа албан бичигтээ шилжүүлсэн, бэлэглэсэн талаар мэдээллийг давхар тодруулах;

2. Үнэт цаас худалдан борлуулах ажиллагааг үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдааны адил тогтмол зохион байгуулж байх;

3. Шийдвэр гүйцэтгэгч нарт үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн талаар сургалт зохион байгуулах.